



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2026 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарын удирдах албан тушаалтны үүрэг, хариуцлагыг сайжруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай

Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалтны хүний нөөцийн томилгоо болон төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, ажилтны ажлын сахилга, хариуцлагыг чангатгах, ёс зүйн манлайллыг сайжруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах албан даалгаврыг өгч байна:

Нэг. Эрүүл мэндийн бүх шатны байгууллагын дарга, захирал нарт:

1.1 "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)"-ийн 2.1 болон 7.4-т заасан зорилтууд, салбарын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж, байгууллагын үйл ажиллагаанд шударга ёсыг бэхжүүлэх;

1.2 Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, иргэнийг ажилд сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хууль тогтоомжийг чанд мөрдөж, хууль бус халаа, сэлгээ, томилгоо хийхгүй байх;

1.3 Сул орон тоонд томилгоо хийхдээ ажлын хэсэг байгуулж, нээлттэй сонгон шалгаруулалт явуулах зарчмыг томилгоо бүрд хэрэгжүүлж, удирдах ажилтнууд ёс зүйн манлайлал үзүүлэх;

1.4 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд бүрийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг Авлигатай тэмцэх газраар заавал хянуулж, дүгнэлт гарсны дараа томилох шийдвэрийг гаргаж хэвших;

1.5 Санхүүгийн сахилга батыг чангатгаж, ажилтнуудад мөнгөн урамшуулал олгохдоо Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т заасан "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" зарчмыг баримтлан, урамшууллыг нэг зориулалтаар давхардуулан олгохгүй байх;

143260009

1.6 Төсвийн шууд захирагч нар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, ажилтнуудад олгосон урамшууллаас эргүүлэн татаж байгууллагын арга хэмжээнд зарцуулахыг хатуу хориглох, шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн гүйцэд байршуулах;

1.7 Үндэсний аудитын газар болон Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмж, дүгнэлтэд тусгагдсан зөрчлийг арилгах төлөвлөгөөг тухай бүр гарган, хэрэгжилтийг бүрэн хангаж, холбогдох байгууллагуудад тайлагнаж байх;

1.8 Байгууллагын үйл ажиллагаа, ажилтнуудын харилцаа, ёс зүйтэй холбоотой иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулах;

1.9 "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо"-ны үйл ажиллагааг эрчимжүүлж, зөрчлийн шинжтэй үйлдлүүдийг тухай бүр хэлэлцэж, хариуцлага тооцож байх;

1.10 Байгууллагын үйл ажиллагаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах.

Хоёр. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаа)-т даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН